

**ЗАМЫН-ҮҮД ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

**ЗАМЫН-ҮҮД СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН  
ХАЛДВАРТЫН ТАСГИЙН ДЭЭВРИЙН ЗАСВАРЫН  
АЖЛЫН ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалтын нэр : “**Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн  
Халдвартын тасгийн дээверийн засвар”  
-ын ажил**

Гэрээний нэр, дугаар: **АХО-А/05/2020**

# ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Дорноговь аймгийн Замын-Үүд Хотын захирагчийн ажлын алба нь эрх бүхий тендерт оролцогдоос “Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн Халдвартын тасгийн дээверийн засварын ажил”-ын цахим тендерт үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 он
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт оролцогч нь төсөвт өртөгийн 50%-тай тэнцэх мөнгөн ба түүнтэй адилтгах хөрөнгийн эх үүсвэртэй байх ба түүнийг баталгаажуулсан баримт /Компаний дансны үлдэгдлийн банкны тодорхойлолт, авах боломжтой зээлийн тодорхойлолт гэх мэт/-ийг гаргаж эх хувь ирүүлэх хуулбарласан тохиолдолд нотариатоор батлуулсан хуулбарыг ирүүлнэ.
- Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 он
- Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Төсөвт өртөгийн 50%-иас дээш хуулбарласан тохиолдолд нотариатоор батлуулсан хуулбарыг ирүүлнэ.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:

**БА-2.1** Цутгамал болон угсармал төмөр бетон мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт өргөтгөл шинэтгэлийн ажил /хүчинтэй хугацаа дуусаагүй байх , хүчинтэй хугацаа дуусч эрх бүхий байгууллагад хүсэлт гарган шийдвэрлэх явцад байгаа зөвшөөрлийг хүчинтэйд тооцож хүлээн авахгүй/

Үнийн санал ирүүлэх ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50 000 төгрөгөөр худалдан авна. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна

Үнийн саналыг нээлттэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020 оны 06-р сарын 22-ний өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Тендерийн материалыг 2020 оны 06-р сарын 22-ний өдрийн 10 цаг 30 минутаас өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим хуудсаар ирүүлнэ.

Дотоодын давуу эрх тооцно

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дорноговь аймаг Замын-Үүд сум Сүлд баг Нутгийн удирдлагын ордон 2 давхар 17 тоот

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |   |
|---|---|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч</b>          | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.   |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>     | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.  |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                 | 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ: <ul style="list-style-type: none"><li>(а) Үнийн санал;</li><li>(б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;</li><li>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;</li><li>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;</li><li>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]</li></ul>  |
| <b>4. Тендерийн үнэ</b>                       | 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.<br>4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.<br>4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтаасан гэж үзнэ.<br>4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстай бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна. |
| <b>5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b> | 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>30</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |
| <b>6. Алдааг запруулах</b>                    | 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар запруулна: <ul style="list-style-type: none"><li>(а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;</li><li>(б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг запруулна;</li><li>(в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны</li></ul>   |

таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<ul style="list-style-type: none"> <li>- Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх</li> <li>- Сүүлийн 2 жилийн туршлагын мэдээллийг нотлох баримтын хамт ирүүлэх / гэрээ, хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн протокол/</li> <li>- Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар</li> <li>- Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл</li> <li>- Харилцагч банкны тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</li> <li>- Татварын газрын тодорхойлолт/өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</li> <li>- Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</li> <li>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</li> <li>-Шүүхийн тодорхойлолт. Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</li> <li>-Аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан / 2018, 2019 он</li> <li>-Гэрээний хугацаанд ажиллах инженер техникийн ажилчдын жагсаалт гарган нотлох баримтын ирүүлэх Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</li> <li>- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: Тендерт оролцогч нь төсөөт өртөгийн 50%-тай тэнцэх мөнгөн ба түүнтэй адилтгах хөрөнгийн эх үүсвэртэй байх ба түүнийг баталгаажуулсан баримт /Компаний дансны үлдэгдлийн банкны тодорхойлолт, авах боломжтой зээлийн тодорхойлолт гэх мэт/-ийг гаргаж эх хувь ирүүлэх хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан хуулбарыг ирүүлнэ.</li> <li>- Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод, гаргацтай, мэдээлэл зөв байрлалтай байх шаардлагатай.</li> <li>- Дээрх баримт бичгүүд нь тендер зарласан өдрөөс хойш авсан байх</li> <li>-ТШӨХ-д шаардсан материалын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</li> <li>-Оролцогч албан ёсны цахим хаяг болон байгууллагын хаяг, утасны дугаарыг бичиж ирүүлэх</li> </ul>

	<p><b>- Дээрх баримт бичгүүд нь тендер зарласан өдрөөс хойш авсан байх</b></p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: <b>БА-2.1</b> Цутгамал болон угсармал төмөр бетон мод ба өрөгт бүтээцэн барилгын угсралт өргөттөл шинэтгэлийн ажил /хүчинтэй хугацаа дуусаагүй байх , хүчинтэй хугацаа дуусч эрх бүхий байгууллагад хүсэлт гарган шийдвэрлэх явцад байгаа зөвшөөрлийг хүчинтэйд тооцож хүлээн авахгүй/ Тендерт оролцогч нь гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй ашиглагдах шаардлагатай дараах үндсэн машин механизм, тоног төхөөрөмжтэй байх шаардлагатай</p> <p><b>Үүнд :</b></p> <p>Гэрээт ажилд ашиглах машин механизм, тоног төхөөрөмжийн гэрчилгээний эхийг скайнердаж ирүүлнэ.</p> <p>Гэрчилгээ шаардагдахгүй тоног төхөөрөмж, багаж, хөдөлмөр хамгааллын хувцас, хамгаалах хэрэгслийн хувьд фото зургийг өнгөтөөр, техникийн үзүүлэлтийн хамт хавсаргаж ирүүлнэ.</p>
<b>ТОӨЗ 2.1</b>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p><b>Тендер хүлээн авах этгээд:</b> tender.gov.mn цахим сайтаар</p> <p><b>Байгууллагын хаяг:</b> Дорноговь аймаг Замын-Үүд сум, Сүлд баг , Нутгийн удирдлагын ордон Давхар болон өрөөний дугаар: 2 давхар 17 тоот Утас:70527500</p> <p><b>Огноо:</b> 2020 оны 06 дугаар сарын 22-ний өдөр Цаг: 10 цаг 30 мин</p> <p><b>Тендерийн хүлээн авах хийх газар, хугацаа нь:</b></p> <p><b>Байшин, гудамжны нэр:</b> Монгол Улс Дорноговь аймаг Замын-Үүд сум, Сүлд</p>
<b>ТОӨЗ 2.1</b>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p><b>Байгууллагын хаяг:</b> Дорноговь аймаг Замын-Үүд сум, Сүлд баг , Нутгийн удирдлагын ордон Давхар болон өрөөний дугаар: 2 давхар 17 тоот</p> <p><b>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:</b> Огноо: 2020 оны 06 дугаар сарын 22-ний өдөр. Цаг: 10 цаг 30 минут.</p>
<b>ТОӨЗ 6.2</b>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бурдэнэ: <b>багц байхгүй</b></p> <p>Барилгын инженер 1 Хөдөлмөр аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн 1 Барилгын инженер нь мэргэжлээрээ 3- аас доошгүй жил ажилласан байх</p>

**ДОРНОГОВЬ АЙМАГ, ЗАМЫН-ҮҮД  
ХАЛДВАРТЫН ЭМНЭЛГИЙН ЗАСВАРЫН АЖИЛ**

**Замын-Үүд сумын 1 –р баг 6 дугаар хэсгийн Халдвартын эмнэлэг нь 15.6м x 16.8м хэмжээтэй, тоосгон хийцтэй, хавтгай дээвэртэй барилга болно.**

**A. Ажил гүйцэтгэх хугацааны график /хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо/-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.**

**B. Эмнэлгийн барилгийн , дээвэрийг, Барилгын норм ба дүрэм /БНБД/, стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх**

**C. Үнийн саналд захиалагчийн хяналтын зардлыг Барилга угсралтын ажлын төсөвт өртгийн дунгийн 2%-иар, тусгаж ирүүлнэ.**

**D. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах**

**E. Барилгын засварын ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ.**

**F. Зураг төсвийн үнэ 1 847 500**

**Дээврийн засварын ажил:**

Дээврийн ажлыг гүйцэтгэхдээ БНБД 31-02-03, БНБД 31-07-05, БНБД 31-08-05, бусад норм, стандартыг мөрдлөг болгоно.

Дээврийн ажлыг дулааны улиралд чанарын маш өндөр түвшинд хийж гүйцэтгэх шаардлагатай. Дээврийн ажлыг зураг төсөвт тусгасны дагуу гүйцэтгэнэ.

Дээврийн хуучирч муудсан хар цаасыг бүхэлд нь хуулж буулган налуулгыг сэргээж 15мм зузаантай бетон тэгшлэгээ хийж өгнө. Дээвэрт битум массаар хөрсжүүлэлт хийх Налуу дээврийг 1γе чулуутай бикрость, 1 γе чулуутгүй бикрость хар цаас наах

Прапедны өрлөгийг засварлаж өрөх

**Гадна фасадны заслын ажил**

Гадна ханын хуурай ба нойтон шавардлага будах өнгөлгөөний ажилд БНБД 31-10-05-г мөрдөнө. Гадна ханын супарч хөндийрсөн шаврыг ховхолж унагах гадна хананд шавардлагын засварыг 20мм зузаан цементэн шохойн зуурмагаар хийх. Гадна ханын гадаргууг 100% хусаж цэвэрлэх хананд цавуун хөрсжүүлэгч хийх будалтанд бэлтгэсэн гадаргуунд замасган тэгшилгээ хийх гадна хананд фактуран өнгөлгөө хийх гадна амалгааг цемент шохойн зуурмагаар шавардах гадна хана сайн чанарын усан эмульсэн будгаар гар аргаар будах гадна амалгаа усан эмульсэн будгаар будах цонхонд усны хаялага төмөр эдлэл хийх

**Дотор заслын ажил**

Дотор ханын хуурай ба нойтон шавардлага, будаг, цааслалт, шилплэгээ, өнгөлгөөний ажилд БНБД 31-10-05-г мөрдөнө. Дотор засварын ажилд БНБД 3.04.02.88-г мөрдөнө. Заслын ажилд хэрэглэх

материалууд нь MNS5252:2003, MNS4584:98, MNS4581:2003 техникийн шаардлагыг хангасан байна. Цонхны амалгааны засварын ажил БНБД3.04.02.88-г мөрдөнө.

Гадна агаарын температур +8 хэмээс багагүй, өрөөний температур +10- с багагүй үед ажлыг гүйцэтгэнэ.

Хуучин таазны гадаргууг 100% хусаж цэвэрлэх таазны хөндийрч суларсан шаврыг ховхолж унагах дотор талын тааз шаврын засварыг цементэн зуурмагаар хийх хананд тэгшилгээ хийж сайн чанарын усан суурьтай будгаар будах таазан тэгшилгээ хийж сайн чанарын эмульсэн будгаар будах

### **Хаалга ажил**

Хаалганы ажилд БНБД 81-55-05, дагуу гүйцэтгэх ба материалын улсын стандартыг мөрдөнө.

Тоосгон хананы хаалганы хайрцаг задлах, шавардлагыг ховхлох 2м2 хүртэл талбайтай бүргэд хаалга суулгах гадна хананд 2 самбартай бүргэд хаалга угсрах дотор тоосгон хананд 3м2 хүртэл табайтай хаалга угсрах хаалганы зайд завсрыйг баллонтой шүршдэг хөөсөөр чигжих хаалганд цоож суулгах

### **Шалны засварын ажил**

Шалны ажилд БНБД3.04.04-90 мөрдлөг болгоно.

Хуучин хулдаас хуулах шаланд цементэн тэгшилгээ хийх хүйтэн түрхлэг дээр хулдаас нааж шал хийх.

Бусад өрөөнд зориулалтын хулдаас наах.

### **Ажлын тоо хэмжээ**

Д/д	Ажилбарын нэр	Хэмжих нэгж	Тоо
<b>01.Дотор заслын ажил</b>			
1	Хуучин будагтай таазны гадаргууг 100% хусаж цэвэрлэх	м2	202.50
2	Таазны хөндийрч суларсан шаврыг ховхолж унагах	м2	89.70
3	Дотор талын таазны шаврын засварыг цементэн зуурмагаар хийх	м2	89.70
4	Таазан тэгшилгээ хийж сайн чанарын эмульсэн будгаар будах	м2	202.50
<b>02. Шалны ажил</b>			
5	Шалны хуучин хулдаас хуулах	м2	167.60
6	Шаланд цементэн тэгшилгээ хийх	м2	127.00
7	Хүйтэн түрхлэг дээр хулдаас нааж шал хийх	м2	127.00
<b>03. Гадна фасад, дээвэр</b>			
8	Гадна ханын супарч хөндийрсөн шаврыг ховхолж унагах	м2	30.90
9	Гадна хананд шавардлагын засварыг 20мм зузаан цементэн шохойн зуурмагаар хийх	м2	30.90
10	Гадна ханын гадаргууг 100% хусаж цэвэрлэх	м2	205.80
11	Хананд цавуун хөрсжүүлэгч хийх	м2	205.80
12	Будалтанд бэлтгэсэн гадаргуунд замасган тэгшилгээ хийх	м2	205.80
13	Гадна хананд фактуран өнгөлгөө хийх	м2	205.80
14	Гадна амалгааг цемент шохойн зуурмагаар шавардах	у/м	63.70
15	Гадна хана сайн чанарын усан эмульсэн будгаар гар аргаар будах	м2	205.80
16	Гадна амалгаа усан эмульсэн будгаар будах	м2	25.50

17	Цонхонд усны хаялага төмөр эдлэл хийх	M2	9.83
18	Хуйлмал материалан дээвэр буулгах	M2	288.00
19	Дээврийн 40 мм зузаан цементэн тэгшилгээ хийх	M2	288.00
20	Дараагийн 1 мм зузаан тутамд үнэлгээ 30-д нэмэх	M2	1,190.00
21	Дээвэрт битум массаар хөрсжүүлэлт хийх	M2	288.00
22	Налуу дээврийг 1үе чулуутай бикрость, 1 үе чулуугүй бикрость хар цаас наах	M2	288.00
23	Пррапедний ханыг цемент шохойн зуурмагаар гараар сайн чанартай шавардах	M2	49.41
24	Пррапедний хананд хэвтээ ус тусгаарлагч шингэн шилтэй цементэн зуурмагаар хийх	M2	24.70
25	Борооны ус зайлцуулах зориулалтын хоолой ф150 мм	M	16
<b>04. Хаалганы ажил</b>			
26	Гадна хананд 2м2 хүртэл талбайтай бүргэд хаалга суулгах	Ш	4.00
27	Гадна хананд 2 самбартай металл хаалга угсралт	Ш	2.00
<b>05. Хог хаяндалын дүн</b>			
28	Хог хаягдал	TH	0.00

**Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:**

1. Барилгын засварын ажлыг батлагдсан зураг төсөл, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Барилгын ажлыг эхлүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах, хашаа барих зэрэг шаардлагатай арга хэмжээг авч гэнэтийн аюул осол гаргахгүй байхаар ажиллана.
4. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.
5. Барилгын талбайд ажлын журнал, батлагдсан зураг төсөл, хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.
6. Барилгын засварын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
7. Барилгын зураг төсөлд зааснаас зайлшгүй тохиолдолд өөрчлөлт оруулах болвол захиалагч болон зураг төслийн байгууллагатай зөвшилцөнө. Зөвшөөрөлгүйгээр газар дээр өөрчлөхийг хориглоно.
8. Барилгын тухай хуулийн 14.3-т заасны дагуу ашиглалтанд хүлээлгэн өгснөөс хойш зүгшрүүлэх, тохиуулах хугацаа нэг жил байна. Энэ хуулийн 14.6 заасны дагуу 14.3-т заасан хугацаа

дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хий, бүтээц, цэвэр бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.

9. Гүйцэтгэсэн ажлыг ил, далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.
10. Хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 7 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөгүй тохиолдолд зураг төсвийн дагуу гүйцэтгэнэ.
11. Гүйцэтгэгч нь барилгын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг бүрэн биелүүлнэ.
12. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцааг эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.
13. Үнийн саналд Барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, төлөвлөгөөт ашиг, техник хяналт, нормчлолын сан, НӨАТ, магадлашгүй ажлын зардал зэргийг тооцож Барилгын төсөв зохиох дүрэм БНБД “ГҮ” 81-95-12-г мөрдлөг болгоно.
14. Автомэханикийн зардлыг ЗТЯ-ны 2013.07.10-ны өдрийн 162 тоот тушаалаар батлагдсан жишиг тарифаар тооцно.
15. ЗТБХБС-ын 2012 оны 18 дугаар тушаалаар машин механизмын зардлыг тооцож ирүүлнэ.
16. Үнийн тарифийг тооцон ирүүлэхдээ ажилбар тус бүрээр тооцож ирүүлнэ.

## ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА

### Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

#### Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

##### Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

- (а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;
- (б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

## **Ажил-өдрийн хуваарь**

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

(а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.

(б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

### **Магадлашгүй зардал**

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарыт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийг өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарыт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

*Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг болоевсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.*

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

**Хотын захирагчийн ажлын албаны дарга Ц.Саруулсайхан танаа**

- Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
- Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <p>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</p> <p>2. Төслийн менежерийн шийдвэр</p> <p>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</p> <p>4. Аюулгүй байдал</p> <p>5. Зааварчилгаа</p> <p>6. Маргааныг шийдвэрлэх</p> <p>7. Ажлын хөтөлбөр</p> <p>8. Зөрчил, гологдол илрүүлэх</p> <p>9. Зөрчил, гологдол арилгах</p> <p>10. Зөрчил, гологдол арилгахгүй байх</p> | <p>1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.</p> <p>2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.</p> <p>3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.</p> <p>4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.</p> <p>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.</p> <p>5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй</p> <p>6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.</p> <p><b>Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ</b></p> <p>7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.</p> <p>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.</p> <p>8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдолтын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.</p> <p>9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа<sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.</p> <p>9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.</p> <p>10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.</p> |
|---|---|

## В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- |  |   |
|--|---|
| <b>11. Үе шатны ажлын хуваарь</b>                      | <p>11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарын тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.</p> <p>11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.</p>   |
| <b>12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх</b>            | <p>12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарын нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.</p>  |
| <b>13. Алданги</b>                                     | <p>13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алдангий<sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.</p>   |
| <b>Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ</b>                               |   |
| <b>14. Ажил дуусгах</b>                                | <p>14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлцуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.</p>  |
| <b>15. Хүлээж авах</b>                                 | <p>15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.</p>   |
| <b>16. Эцсийн тооцоо</b>                               | <p>16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.</p> <p>Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.</p> <p>Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай запруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.</p> |
| <b>17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага</b> | <p>17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.</p> <p>17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.</p>  |

- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
  - 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
    - (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
    - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
    - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буудсан;
    - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
    - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
  - 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
  - 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

### Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ<sup>3</sup>

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: “Замын-Үүд сумын Нэгдсэн эмнэлгийн Халдвартын тасгийн дээврийн засварын ажил”-ын ажил АХО-А/05/2020
ГЕН 2.1	Ажил нь [төвч тодорхойлолт, түүний дотор төслийн хүрээнд бусад гэрээтэй]

	холбогдох байдал]-аас бүрдэнэ. Ажлын талбай нь : <b>Дорноговь аймгийн Замын-Үүд сум</b>
<b>ГЕН 3.1</b>	Төслийн менежер нь [томилогдсон этгээдийн нэр, хаяг]
<b>ГЕН 4.1</b>	Ажил эхлэх өдөр: <b>2020.06.30</b> Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <b>2020.07.30</b>
<b>ГЕН 7.1</b>	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <b>5</b> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
<b>ГЕН 9.1</b>	Чанарын баталгаат хугацаа <b>3 жил</b> байна.
<b>ГЕН 13.1</b>	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <b>0,2%</b> байна.  Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <b>30%-иас</b> багагүй байна.
<b>ГЕН 17.1</b>	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <b>5</b> -ны дотор гаргаж өгнө.  Гүйцэтгэлийн зургийг <b>5</b> -ны дотор гаргаж өгнө.  Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд сутгах төлбөрийн хэмжээ [мөнгөн дүн] байна.
<b>ГЕН 19.1</b>	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын [хувь]-иар тооцно.

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

**ЗАХИАЛАГЧ**

**ГҮЙЦЭТГЭГЧ**

(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулхтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

**3.** Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

**4.** Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ хүчилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилууллах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

**5.** Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Зураг;
- 5.8.** Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9.** Санхүүжилтийн хуваарь;
- 5.10.** Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

**6.** Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

**7.** Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

**8.** Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

**9.** Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

#### **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

#### **ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]